



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2017 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/86

Өлгий


**Комисс байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, Засгийн газрын 2017 оны 69 дүгээр тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Азат" ХХК-ийн хөрөнгө оруулалтаар "Банкер" ХХК-ийн гүйцэтгэсэн Өлгий сумын 13 дугаар багт баригдсан махны үйлдвэр, хөргүүртэй агуулах, гүн хөлдөөх агуулах, зуухны барилгын ажлыг ашиглалтад хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга:	З.Болат	-ХОХБТХ-ийн дарга
Гишүүд	Х.Ербулан	-Аймгийн ОБГ-ын гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахлах дэслэгч
	Ө.Асылбек	-Аймгийн МХГ-ын барилгын улсын хяналтын байцаагч
	К.Асан	- Аймгийн МХГ-ын мал, амьтны хорио цээр, чанарын улсын хяналтын байцаагч
	Б.Досжан	- Архивын тасгийн эрхлэгч
	Х.Асхар	- Аймгийн ГХБХБГ-ын хэлтсийн дарга
	Х.Бөрдмурат	- "Азат" ХХК-ийн захирал
	Н.Муратхан	- "Банкер" ХХК-ийн ерөнхий инженер
	С.Галя	- "АЕСН" ХХК-ийн захирал
	Х.Ермурат	- Аймгийн ГХБХБГ-ын мэргэжилтэн
	А.Мерей	- ЦШСГ-ын ХХААБ-ын инженер
	Х.Ерханат	- "СУАТ" НААҮГ-ын ус сувгийн инженер
Нарийн бичгийн дарга	С.Ержан	- Барилга захилагчийн албаны инженер

2. Өлгий сумын 13 дугаар багт баригдсан махны үйлдвэр, хөргүүртэй агуулах, гүн хөлдөөх агуулах, зуухны барилгын ажлыг зураг төсөв, техникийн үзүүлэлт, стандартын шаардлагын дагуу гүйцэтгэсэн эсэхт дүгнэлт хийж зохих хууль, журмын дагуу ашиглалтад хүлээн авах ажиллагааг зохион байгуулахыг комисс / З.Болат/-т үүрэг болгосугай.



000202